



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/48/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом хот  
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:  
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-  
Amgalanm@audit.gov.mn

Утас: 70453799, Цахим хаяг:  
Munkhtogtokhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН  
ДАРГА Б.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

2023.02.13 № УВА-2023/48/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн тушаалаар Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийг 96 орон тоотой байхаар баталсан байна.

**Аудитын гол асуудал**

Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 385 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгө актлах шийдвэр гарч хуучин конторын барилгыг данс бүртгэлээс хассан байна.

Бусад асуудлын хэсэгт: Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн хувьд бусад асуудлын хэсэгт дурдах зүйлгүй байна.

0260200395

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>243,874,074.94</u></b>	<b><u>238,307,727.94</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	243,874,074.94	238,307,727.94
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	238,071,000.24	229,073,653.24
35110	Тусгай зориулалттай материал	238,071,000.24	229,073,653.24
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	5,803,074.70	9,234,074.70
35420	Аж ахуйн материал	5,803,074.70	8,964,074.70
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	270,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,117,409,828.16</u></b>	<b><u>2,061,390,586.80</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,117,409,828.16	2,061,390,586.80
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,603,475,272.60	1,547,929,364.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,819,939,849.00	1,437,874,249.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-452,551,111.71	-139,835,710.97
39203	Авто-тээврийн хэрэгсэл	71,867,573.78	74,517,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,464,618.35	-23,850,125.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	309,540,919.07	392,279,888.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-135,329,900.89	-199,063,695.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6,818,500.00	6,898,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,491,938.30	-4,037,214.22
39217	Ном	3,146,000.00	3,146,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	513,934,555.56	513,461,222.28
39301	Програм хангамж	1,900,000.00	1,900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-529,444.44	-1,002,777.72
39303	Бусад биет бус хөрөнгө	512,564,000.00	512,564,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,361,283,903.10</u></b>	<b><u>2,299,698,314.74</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,361,283,903.10</u></b>	<b><u>2,299,698,314.74</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,361,283,903.10	2,299,698,314.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,016,818,934.41	1,016,818,934.41
51101	Өмч: - төрийн	1,016,818,934.41	1,016,818,934.41
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,247,787,484.50	1,263,302,159.33
51210	Өмнөх үеийн үр дүн	1,247,787,484.50	1,324,887,747.69
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-61,585,588.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	96,677,484.19	19,577,221.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,361,283,903.10</u></b>	<b><u>2,299,698,314.74</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,621,254,401.37</b>	<b>1,638,137,669.98</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>263,966,943.37</b>	<b>248,608,669.98</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	263,966,943.37	248,608,669.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	263,966,943.37	85,633,968.98
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	467,097.00	245,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,357,287,458.00</b>	<b>1,389,529,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,330,323,600.00	1,347,530,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,330,323,600.00	1,347,530,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	26,963,858.00	41,998,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	3,436,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,437,958.00	3,390,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,525,900.00	5,172,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,546,627,584.53</b>	<b>1,668,945,753.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,546,627,584.53</b>	<b>1,668,945,753.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,492,305,152.23	1,646,172,547.84
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	999,311,597.00	1,113,031,667.00
210101	Үндсэн цалин	727,204,743.00	836,975,904.00
210102	Нэмэгдэл	247,817,416.00	241,015,850.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,289,438.00	30,072,700.00
210104	Урамшуулал	00.00	4,967,213.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	131,480,611.00	141,499,546.00
210201	Тэтгэврийн даатгал	91,279,094.88	97,802,312.02
210202	Тэтгэмжийн даатгал	9,219,616.69	10,984,819.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,870,420.08	8,770,655.83
210204	Ажилгүйдлийн даатгал	2,009,582.26	2,174,099.03
210205	Эрүүл мэндийн даатгал	20,101,897.09	21,767,659.36
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	51,697,521.64	52,208,528.00
210301	Гэрэл, цахилгаан	6,423,295.64	10,150,380.00
210302	Түлш, халаалт	42,371,226.00	39,357,220.00
210303	Цэвэр, бохир ус	2,903,000.00	2,700,928.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,116,514.87	14,907,621.00
210401	Бичиг хэрэг	2,968,900.00	1,129,900.00
210402	Тээвэр, шатахуун	7,586,840.00	9,342,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,191,774.87	2,815,871.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,369,000.00	1,619,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	728,000.00	612,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	728,000.00	612,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,139,600.00	2,413,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	200,000.00
210604	Урсгал засвар	3,139,600.00	2,213,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,816,000.00	4,622,000.00
210702	Дотоод албан томилолт	3,816,000.00	4,622,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	80,875,858.19	10,414,632.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,070,378.19	4,467,302.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,104,800.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	128,700.00	183,150.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	89,880.00	44,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	586,500.00	396,000.00
210807	Газрын төлбөр	4,840,600.00	4,779,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>205,139,449.53</b>	<b>306,462,853.84</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	121,005,020.35	195,672,248.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	315,000.00	80,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83,819,429.18	110,710,605.84
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,322,432.30</b>	<b>22,773,206.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>44,049,500.00</b>	<b>900,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	900,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,272,932.30</b>	<b>21,873,206.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,272,932.30	21,873,206.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>74,626,816.84</b>	<b>-30,808,083.86</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>377,183.29</b>	<b>30,777,504.50</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	377,183.29	30,777,504.50
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-377,183.29</b>	<b>-30,777,504.50</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>74,249,633.55</b>	<b>-61,585,588.36</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,384,068,934.00</b>	<b>1,389,774,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>467,097.00</b>	<b>245,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>467,097.00</b>	<b>245,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	467,097.00	245,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	467,097.00	245,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,383,601,837.00</b>	<b>1,389,529,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,330,323,600.00</b>	<b>1,347,530,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,330,323,600.00	1,347,530,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>26,963,858.00</b>	<b>41,998,500.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	3,436,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	30,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,437,958.00	3,390,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,525,900.00	5,172,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,384,068,934.00</b>	<b>1,389,694,100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,384,068,934.00</b>	<b>1,389,694,100.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,303,432,122.70</b>	<b>1,366,920,894.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>999,311,597.00</b>	<b>1,105,735,313.00</b>
210101	Үндсэн цалин	727,204,743.00	829,377,200.00
210102	Нэмэгдэл	247,817,416.00	241,318,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,289,438.00	30,072,700.00
210104	Урамшуулал	00.00	4,967,213.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>131,480,611.00</b>	<b>148,795,900.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	91,279,094.88	105,373,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,050,001.05	10,855,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,040,035.72	8,684,600.00

210204	Ажилгүйдлийн даатгал	2,009,582.26	2,171,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,101,897.09	21,711,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>51,697,521.64</b>	<b>52,208,528.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,073,395.64	10,150,380.00
210302	Түлш, халаалт	41,721,126.00	39,357,220.00
210303	Цэвэр, бохир ус	2,903,000.00	2,700,928.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,372,414.87</b>	<b>14,685,421.00</b>
210401	Бичиг хэрэг	2,956,400.00	1,129,900.00
210402	Тээвэр, шатахуун	7,761,840.00	9,379,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,191,774.87	2,775,871.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,462,400.00	1,400,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>728,000.00</b>	<b>1,968,400.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	1,356,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	728,000.00	612,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,272,700.00</b>	<b>3,029,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	198,000.00	530,000.00
210604	Урсгал засвар	2,074,700.00	2,499,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,816,000.00</b>	<b>4,622,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,816,000.00	4,622,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>81,075,858.19</b>	<b>10,454,632.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,270,378.19	4,467,302.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,104,800.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	128,700.00	183,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	89,880.00	44,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	586,500.00	436,000.00
210807	Газрын төлбөр	4,840,600.00	4,779,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,677,420.00</b>	<b>25,421,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,362,420.00	25,156,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	315,000.00	264,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>80,636,811.30</b>	<b>22,773,206.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>70,363,879.00</b>	<b>900,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	900,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,272,932.30</b>	<b>21,873,206.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,272,932.30	21,873,206.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>79,900.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>79,900.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>79,900.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>79,900.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	79,900.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-79,900.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	1,016,818,934.41	00.00	00.00	1,016,818,934.41
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	59,391,162.00	59,391,162.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,016,818,934.41</b>	<b>00.00</b>	<b>59,391,162.00</b>	1,076,210,096.41
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	74,249,633.55	74,249,633.55
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,016,818,934.41</b>	<b>96,677,484.19</b>	<b>1,247,787,484.50</b>	2,361,283,903.10
<b>2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>1,016,818,934.41</b>	<b>96,677,484.19</b>	<b>1,247,787,484.50</b>	2,361,283,903.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	77,100,263.19	77,100,263.19
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,016,818,934.41</b>	<b>96,677,484.19</b>	<b>1,324,887,747.69</b>	2,438,384,166.29
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-77,100,263.19	00.00	-77,100,263.19
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-61,585,588.36	-61,585,588.36
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,016,818,934.41</b>	<b>19,577,221.00</b>	<b>1,263,302,159.33</b>	2,299,698,314.74

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,347,730,500.00</b>	<b>1,325,902,294.00</b>	<b>21,828,206.00</b>	<b>98.3</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,347,730,500.00</b>	<b>1,325,902,294.00</b>	<b>21,828,206.00</b>	<b>98.3</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,326,919,600.00</b>	<b>1,325,902,294.00</b>	<b>1,017,306.00</b>	<b>99.9</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,105,768,100.00</b>	<b>1,105,735,313.00</b>	<b>32,787.00</b>	<b>100.0</b>
Үндсэн цалин	829,377,200.00	829,377,200.00	0.00	100.0
Нэмэгдэл	241,318,200.00	241,318,200.00	0.00	100.0
Унаа хоолны Хөнгөлөлт	30,072,700.00	30,072,700.00	0.00	100.0
Урамшуулал	5,000,000.00	4,967,213.00	32,787.00	99.3
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>148,795,900.00</b>	<b>147,795,900.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
Тэтгэврийн даатгал	105,373,200.00	105,373,200.00	0.00	100.0
Тэтгэмжийн даатгал	10,855,700.00	10,855,700.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	8,684,600.00	8,684,600.00	0.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	2,171,100.00	2,171,100.00	0.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	21,711,300.00	21,711,300.00	0.00	100.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>48,322,400.00</b>	<b>48,320,328.00</b>	<b>2,072.00</b>	<b>100.0</b>
Гэрэл, цахилгаан	9,282,400.00	9,282,400.00	0.00	100.0
Түлш, халаалт	36,487,000.00	36,487,000.00	0.00	100.0
Цэвэр, бохир ус	2,553,000.00	2,550,928.00	2,072.00	99.9
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,401,400.00</b>	<b>8,395,921.00</b>	<b>4,850.00</b>	<b>99.9</b>
Бичиг хэрэг	379,900.00	379,900.00	0.00	100.0
Тээвэр, шатахуун	3,895,000.00	3,890,150.00	4,850.00	99.9

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,726,500.00	2,725,871.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,400,000.00	1,400,000.00	0.00	100.0
<b>Норматив зардал</b>	<b>1,224,800.00</b>	<b>612,400.00</b>	<b>612,400.00</b>	<b>50.0</b>
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,224,800.00	612,400.00	612,400.00	50.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,816,500.00</b>	<b>1,816,500.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
Багаж, техник хэрэгсэл	417,500.00	409,900.00	7,600.00	98.2
Урсгал засвар	1,399,000.00	1,399,000.00	0.00	100.0
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,904,900.00</b>	<b>1,874,000.00</b>	<b>30,900.00</b>	<b>98.4</b>
Дотоод албан томилолт	1,904,900.00	1,874,000.00	30,900.00	98.4
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,155,800.00</b>	<b>10,094,632.00</b>	<b>61,168.00</b>	<b>99.4</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,108,100.00	4,107,302.00	798.00	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	185,300.00	183,150.00	2,150.00	98.8
Тээврийн хэрэгслийн татвар	84,300.00	44,280.00	40,020.00	52.5
Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	44,000.00	11,000.00	80.0
Мэдээллэл технологийн үйлчилгээ	443,200.00	436,000.00	7,200.00	98.4
Газрын төлбөр	4,779,900.00	4,779,900.00	0.00	100.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>264,000.00</b>	<b>264,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	264,000.00	264,000.00	0.00	100.0
Урсгал шилжүүлэг	20,810,900.00	0.00	20,810,900.00	
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>20,810,900.00</b>	<b>0.00</b>	<b>20,810,900.00</b>	
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,810,900.00	0.00	20,810,900.00	
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,347,730,500.00</b>	<b>1,325,657,294.00</b>	<b>21,828,206.00</b>	<b>100.0</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,347,730,500.00</b>	<b>1,325,657,294.00</b>	<b>21,828,206.00</b>	<b>100.0</b>
Улсын төсвөөс санхүүжих	1,347,530,500.00	1,325,657,294.00	21,828,206.00	100.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	200,000.00	245,000.00	(45,000.00)	122.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөг/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		41,998,500.00	(41,998,500.00)	
УРСГАЛ ЗАРДАЛ		41,998,500.00	(41,998,500.00)	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		41,998,500.00	(41,998,500.00)	
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>3,888,200.00</b>	<b>3,888,200.00</b>	
Гэрэл, цахилгаан		867,980.00	(867,980.00)	
Түлш, халаалт		2,870,220.00	(2,870,220.00)	
Цэвэр, бохир ус		150,000.00	(150,000.00)	
Хангамж, бараа материалын зардал		6,447,200.00	(6,447,200.00)	
Бичиг хэрэг		750,000.00	(750,000.00)	
Тээвэр, шатахууны зардал		5,489,500	(5,489,500)	
Шуудан холбоо интернет		50,000.00	(50,000.00)	
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		157,700.00	(157,700.00)	
<b>Норматив зардал</b>		<b>1,198,300.00</b>	<b>(1,198,300.00)</b>	
Эм бэлдмэл эмнэгийн хэрэгсэл		1,198,300.00	(1,198,300.00)	
<b>Эд хошил худалдан авах</b>		<b>1,300,000.00</b>	<b>(1,300,000.00)</b>	

Багаж, техник, хэрэгсэл		200,000.00	(200,000.00)	
Урсгал засвар		1,100,000.00	(1,100,000.00)	
<b>Томилолт, зочны зардал</b>		<b>2,748,000.00</b>	<b>(2,748,000.00)</b>	
Дотоод албан томилолт		2,748,000.00	(2,748,000.00)	
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>		<b>360,000.00</b>	<b>(360,000.00)</b>	
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		360,000.00	(360,000.00)	
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>25,156,800.00</b>	<b>(25,156,800.00)</b>	
Бараа үйлчилгээний бусад зардал		25,156,800.00	(25,156,800.00)	
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>900,000.00</b>	<b>(900,000.00)</b>	
Бусад урсгал шилжүүлэг		900,000.00	(900,000.00)	
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал		900,000.0	(900,000.00)	
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		65,000	<b>0.00</b>	
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>41,998,500.00</b>	<b>(41,998,500.00)</b>	
Нэмэлт санхүүжилтийн орлого		41,998,500.00	(41,998,500.00)	
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого		41,998,500.00	(41,998,500.00)	
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00	
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь эрхэм зорилгын хүрээнд Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, улсын сүлжээний тасралтгүй байдал, хөтөлбөрт ажлыг зохион байгуулах, цаг агаар, орчны төлөв байдлын бодит болон урьдчилсан мэдээ, мэдээллээр ард иргэд аж ахуйн нэгжийг мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах, хүний нөөц, төсөв санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн тушаалаар Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийг нийт 96 орон тоотой байхаар баталсан байна.

УЦУОШТөв нь захиргаа санхүү аж ахуйн хэлтэс-8, цаг уур, орчны технологийн хэлтэс-72, мэдээлэл үйлчилгээний хэлтэс-8, Наранбулаг, Хөх толгой өртөө-8, нийт 96 албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

2022 онд тус төв 99.4 хувиар дүгнэгдэж улсын хэмжээнд 2-р байр эзэлсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Агаар, усны тухай хууль, Засгийн газрын холбогдох тогтоол, тушаал, шийдвэр, Аймгийн засаг даргын захирамж, Төрийн албаны тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Увс аймгийн Ус цаг, уурын орчны шинжилгээний төвийн даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ний А/40 дугаар тушаалаар тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 6

хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах, дутагдсан хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар санал дүгнэлтийг гаргажээ.

Төвийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 56,405.5 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.00	0.00	0.00
Бараа материал	243,874.0	238,307.7	-5,566.3
Үндсэн хөрөнгө	2,117,409.8	2,061,390.5	-56,019.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,361,283.9</b>	<b>2,299,698.3</b>	<b>-61,585.6</b>
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,361,283.9	2,299,698.3	-61,585.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,361,283.9</b>	<b>2,299,698.3</b>	<b>-61,585.6</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 238,307.7 мянган төгрөг болж 5,566.3 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал зарцуулснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,061,390.5 мянган төгрөг болж 56,019.3 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 385 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгө актлах шийдвэр гарч хуучин конторын барилгыг данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,299,698.3 мянган төгрөг болж 61,585.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,602.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 254.7 сая төгрөгөөр хорогдуулж, 1,347.5 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэсэн мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулиар 2 удаагийн төсөв тансанаас шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 254.7 сая төгрөгөөр хорогдуулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,347.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,325.6 сая төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардал 20.8 сая төгрөгийг зарцуулаагүй үлдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Ус цаг уур, орчны шинжилгээ / үндсэн үйл ажиллагаа 71408/80101	1,324,471.1	1,323,410.8	1,062.3	99.9
2	Ус цаг уур, орчны шинжилгээ / холбоо суваг ашигласны хөлс 701408 /80220	2,246.5	2,246.5	0.0	100.0
3	Ус цаг уур, орчны шинжилгээ / ажил олгогчоос олгох тэтгэмж 71408/80802	20,810.9	0.0	20,810.9	0.0
<b>ДҮН</b>		<b>1,347,730.5</b>	<b>1,325,657.3</b>	<b>21,873.2</b>	<b>98.3</b>

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал нь 3.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 61.1 мянга, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардал 612.4 мянга, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 20,810.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хууль болон тайлант онд тэтгэвэрт гарах байсан ажилтан бичиг баримтын зөрчилтэй дараа онд гарахаар болсонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын А/14 тоот захирамжаар эрх шилжүүлж засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилтээс 30.0 сая төгрөг орж ирснийг цаг

агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд зарцуулсан, мөн Дэлхийн байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр Бэлчээрийн төлөв байдлын ажиглалт судалгаа, Мөнх цас мөсөн голын ажиглалт судалгааны ажлаар 3.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого 5.1 сая төгрөг, УЦУОШГ-ын даргын А/18 дугаар тушаалаар 3.3 сая төгрөг, нийт 41.9 төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр байхгүй байна.

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

#### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1,546.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 15.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,668.9 сая төгрөгийн 1.0 хувь буюу 16.6 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 13.3 сая төгрөгөөр тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. /АБ-4/ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 148, хугацаа хоцроож 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

 Ч.МӨНХТОГТОХ/

2023 оны 02 сарын 13-ны өдөр